



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2026.04.23 № 22

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн биелэлтийн талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуултыг Танд тавьж байна.

Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах нь Засгийн газрын үндсэн үйл ажиллагаа бөгөөд иргэдийн зүгээс Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой санал, гомдол ихээр ирж байна. Тодруулбал, Сангийн яам болон Худалдан авах ажиллагааны газар, холбогдох тендерийн захиалагч нар нь эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашигладаг, авлигажсан, тендерт тавигдах шаардлага, шалгуурыг хууль зөрчиж боловсруулан бусдад давуу байдал бий болгох үйлдэл, эс үйлдэхүй гаргаж байгаа тухай асуудлаас хамааран хууль тэгш бус үйлчлэх, хуулийг ялгамжтай хэрэглэх байдал байсаар байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт, Засгийн газрын худалдан авах үйл ажиллагаа болон үүнтэй холбогдуулан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай зэрэг холбогдох хууль зөрчигдсөөр байгаа асуудлын хүрээнд:

1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчсөн талаарх шүүхээр шийдвэрлэгдсэн маргаан, түүний шийдвэрлэлтийн талаарх 2020-2025 оны байдлаарх ерөнхий статистик мэдээлэл;

2.Тус хуулийн хэрэгжилттэй холбогдуулан иргэдийн өргөдөл, гомдолд дурдсан “Шивээ овоо” ХК-ийн 2021-2025 онд зарласан тендерүүдэд хууль хэрэгжихгүй байгаа талаарх баримтын хүрээнд “Шивээ овоо” ХК-иас ШО/202107367/01/01 дугаартай 9,461,522,058 төгрөгийн төсөвт өртөгтэй нээлттэй тендер шалгаруулалтын зарлалыг 2021 оны 07 сарын 28-ний өдөр tender.gov.mn цахим хуудаст Тендерийн баримт бичиг буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт [ТШӨХ]-н 18 дугаар зүйлд заасан дараах шаардлагыг хангасан баримт бичиг хүлээн авахаар байршуулсан.

- ТШӨХ “18.1 (б)-д Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: [2020 он], [Аудитын дүгнэлтийн хамт];
- ТӨӨЗ 18.1 (г) Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: [2020-2021 он], [Маягтын хамт гэрээний хуулбар], Одоо хэрэгжиж буй гэрээний талаарх мэдээлэл;
- ТӨӨЗ 18.2 (б) Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: [2020-2021 он];
- ТӨӨЗ 18.2 (д) Ашигтай ажилласан байх жилийн тоо: [2020 он];
- ТӨӨЗ 17.1 (в) Тусгай зөвшөөрөл: [Шаардлагатай] гэж тус тус заасан.

Гэтэл 2021 оны 5 дугаар сарын 21-ний өдөр үүсгэн байгуулсан ажлын болон санхүүгийн түүхгүй “Өү Жи Энержи Ойл” ХХК-ийг өрсөлдөгчгүйгээр шалгаруулж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон ТШӨХ-д заасан шаардлага шалгуурыг зөрчин 9,461,522,058.00 төгрөгийн төсөвт өртөг бүхий тус тендерийг өгсөн нь холбогдох хууль тогтоомж зөрчсөн эсэх;

3.“Шивээ овоо” ХК-иас ШО/202201049/01/01 дугаартай 8,410,317,080 төгрөгийн төсөвт өртөг бүхий нээлттэй тендер шалгаруулалтын зарлалыг 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр tender.gov.mn цахим хуудаст байршуулсан. Тендерийн баримт бичигтэй танилцахад Тендерийн өгөгдлийн хүснэгт (ТӨХ)-ийн ТШЗ18.2.4-т Борлуулалтын хэмжээ:- [Шаардахгүй] гэж заасан нь хуульд нийцсэн эсэх;

4.“Шивээ овоо” ХК-иас ШО/202201050/01/01 дугаартай 9,880,247,520 төгрөгийн төсөвт өртөгтэй нээлттэй тендер, ШО/202209154/01/01 дугаартай 9,797,894,150 төгрөгийн төсөвт өртөгтэй нээлттэй тендер, ШО/202301049/02/01 дугаартай 33,953,742,537 төгрөгийн төсөвт өртөгтэй нээлттэй тендер, ШО/20240102031/02/01 дугаартай 26,752,393,773 төгрөгийн төсөвт өртөгтэй нээлттэй тендер, ШО/20240102391/04/01 дугаартай 4,080,474,090 төгрөгийн төсөвт өртөгтэй нээлттэй тендерүүдэд “Өү Жи Энержи Ойл” ХХК өрсөлдөгчгүй оролцож, ялагч болсон үйлдэл хуульд нийцсэн эсэх;

Мөн дээрх тендерүүдийн эхний хоёр тендер болох 9,880,247,520 болон 9,797,894,150 төгрөгийн төсөвт өртөгтэй тендерт оролцох хуулийн этгээдийн борлуулалтын хэмжээ шаардахгүй, ижил төстэй ажлын өртөг шаардахгүй, түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээг тус тус шаардахгүй гэж ТШӨХ-д бичсэн нь “Өү Жи Энержи Ойл” ХХК-ийн тухайд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай 2005 оны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.” гэж заасан өрсөлдөх тэгш боломж, үр ашигтай, хэмнэлттэй байх зарчим шууд зөрчигдсөн эсэх;

5.“Шивээ овоо” ХК-иас ШО/20250102029/01/01 дугаартай 33,922,462,353.00 төгрөгийн төсөвт өртөгтэй нээлттэй тендер шалгаруулалт зарласан бөгөөд анх удаа “Өү Жи Энержи Ойл” ХХК-иас гадна НИК ХХК, Содмонгол групп ХХК, Шунхлай ХХК зэрэг компаниуд өрсөлдсөн. Гэтэл “Шивээ овоо” ХК-ийн тендерийн үнэлгээний хороо Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-д “Оролцогч захиалагчийн тогтоосон техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна” гэж заасан үндэслэлээр НИК ХХК-ийн ирүүлсэн бага үнийн саналаас татгалзаж, “Өү Жи Энержи Ойл” ХХК-ийг шалгаруулсан нь хуульд нийцсэн эсэх талаар;

6. "Өү Жи Энержи Ойл" ХХК нь "Шивээ овоо" ХК-иас зарласан дизель түлш нийлүүлэх ШО/202107367/01/01, ШО/202209154/01/01, ШО/202201050/01/01, ШО/202201049/01/01, ШО/202301049/02/01, ШО/20240102391/04/01, ШО/20240102031/02/01, ШО/20250102029/01/01 дугаартай нийт 108,794,401,841.06 төгрөгийн төсөвт өртөг бүхий тендерүүдэд шалгарсан байх тул дээр дурдсан тендерүүдийн бичиг баримт боловсруулахаас эхлээд шалгаруулж, гэрээ байгуулах хүртэл үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцсэн эсэх талаарх тендер тус бүрээр гаргасан дэлгэрэнгүй мэдээллүүд болно.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлнэ үү.

Асуултын хариуг тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэгт заасны дагуу хэлэлцүүлэхээр төлөвлөж байгааг мэдэгдэж байна.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Л.МӨНХБАЯСГАЛАН

2028000064